



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТАТИСТИКИЙН МЭДЭЭ
2024 оны 5 дугаар сар**

/УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР/

Улаанбаатар хот,
2024 оны 06 сарын 03

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	4
1.1. Ачаа тээвэр.....	5
1.2. Зорчигч тээвэр.....	6
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....	7
2.1. Ачаа тээвэр.....	7
2.1.1. Экспортын ачаа, боомтоор.....	8
2.1.2. Импортын ачаа, боомтоор.....	9
2.1.3. Ачааны нэр төрөл.....	10
2.1.4. Ачаа эргэлт, боомтоор.....	10
2.2. Зорчигч тээвэр.....	11
2.3. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	13
3.1. Ачаа тээвэр.....	13
3.2. Зорчигч тээвэр.....	15
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	17
4.1. Ачаа тээвэр.....	17
4.2. Зорчигч тээвэр.....	18
4.2.2. Олон улсын зорчигч тээвэр.....	19
4.2.3. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
4.3. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	4
Хүснэгт 2. Автотээврийн ачаа.....	7
Хүснэгт 3. Автотээврийн ачааны экспорт, боомтоор.....	8
Хүснэгт 4. Автотээврийн ачааны импорт, боомтоор.....	9
Хүснэгт 5. Автотээврээр тээсэн ачааны нэр төрөл.....	10
Хүснэгт 6. Ачаа эргэлт, боомтоор.....	10
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч тээвэр.....	11
Хүснэгт 8. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
Хүснэгт 9. Төмөр замын ачаа тээвэр.....	13
Хүснэгт 10. Төмөр замын зорчигч тээвэр.....	15
Хүснэгт 11. Агаарын тээврийн ачаа.....	17
Хүснэгт 12. Агаарын тээврийн зорчигч.....	18
Хүснэгт 13. Олон улсын зорчигч тээвэр.....	19
Хүснэгт 14. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
Хүснэгт 15. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	5
Зураг 2. Нийт экспорт.....	5
Зураг 3. Нийт импорт.....	5
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	6

Зураг 5. Олон улсад зорчигч.....	6
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	6
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	7
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	7
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн боомтоор.....	8
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....	9
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар	10
Зураг 12. Автотээврээр зорчсон зорчигч.....	11
Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	12
Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн.....	13
Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	14
Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 5 дугаар сарын хоногийн мэдээ.....	14
Зураг 19. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	15
Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр.....	16
Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор.....	16
Зураг 22. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	17
Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	17
Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	17
Зураг 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	18
Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	18
Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	19
Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	20
Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	20
Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	21
Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	21

Боловсруулсан: Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа,
стандарт, статистикийн хэлтэс

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 5 дугаар сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ¹

Хүснэгт 1

Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт бууралтын % /Өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	4394.49	24,046.3	7,877.2	32,665.9	35.8%
	Төмөр зам	мян.тн	2822.8	15,361.7	3,377.4	17,518.8	14.0%
	Агаарын тээвэр	мян.тн	0.61	3.48	0.78	3.73	7.1%
	Нийт ачаа	мян.тн	7,217.9	39,411.5	11,255.4	50,188.4	27.3%
Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	449.7	1,998.1	488.7	2,171.0	8.7%
Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	930.0	4,831.8	897.0	4,455.7	-7.8%
	Автотээвэр	мян.тн	4,172.2	23,350.1	7,624.7	31,744.0	35.9%
	Нийт	мян.тн	5,102.2	28,181.9	8,521.7	36,199.8	28.5%
Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	330.9	1,395.1	300.2	1,641.0	17.6%
	Автотээвэр	мян.тн	222.3	696.2	252.5	921.8	32.4%
	Нийт	мян.тн	553.2	2,091.3	552.7	2,562.9	22.5%
Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,112.2	7,136.7	1,691.4	9,250.9	29.6%
	Агаарын тээвэр	мян.тн	0.61	3.48	0.78	3.73	7.1%
	Нийт	мян.тн	1,112.8	7,140.2	1,692.2	9,254.7	29.6%
Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	сая тн/км	636.0	3,716.5	1,050.8	4,669.9	25.7%
	Төмөр зам	сая тн/км	1,601.5	7,745.5	1,530.2	7,846.9	1.3%
	Агаарын тээвэр	сая тн/км	1.7	9.7	2.7	12.5	29.2%
	Нийт ачаа эргэлт	сая тн/км	2,239.2	11,471.7	2,583.9	12,529.3	9.2%
Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,818.3	59,906.6	13,876.4	61,673.3	2.9%
	Төмөр зам	мян.хүн	195.9	850.0	162.9	733.7	-13.7%
	Агаарын тээвэр	мян.хүн	119.3	540.9	163.8	714.3	32.1%
	Нийт зорчигч	мян.хүн	14,133.5	61,297.5	14,203.2	63,121.4	3.0%
Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	67.4	247.8	60.0	201.0	-18.9%
	Төмөр зам	мян.хүн	1.9	6.6	4.2	14.0	112.0%
	Агаарын тээвэр	мян.хүн	85.6	387.8	126.6	546.4	40.9%
	Нийт олон улсад зорчигч	мян.хүн	154.9	642.2	190.8	761.5	18.6%
Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	114.3	561.9	154.0	694.5	23.6%
	Төмөр зам	мян.хүн	194.0	843.4	158.7	719.7	-14.7%
	Агаарын тээвэр	мян.хүн	33.7	153.1	37.3	167.9	9.6%
	Нийт орон нутагт зорчигч	мян.хүн	342.0	1,558.5	350.0	1,582.2	1.5%
Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,636.6	59,096.8	13,662.4	60,777.7	2.8%
Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн/ км	182.7	837.4	201.6	850.8	1.6%
	Төмөр зам	сая хүн/ км	74.4	302.5	65.2	303.8	0.4%
	Агаарын тээвэр	сая хүн/ км	239.30	1,192.37	351.45	1,650.84	38.5%
	Нийт зорчигч эргэлт	сая хүн/км	496.4	2,332.2	618.2	2,805.4	20.3%
Олон улсын хөөрөлт. буултын тоо		ш	664	3,008	931.0	4,213.0	40.1%
Орон нутгийн хөөрөлт. буултын тоо		ш	721	3,109	832.0	3,256.0	4.7%
Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо		ш	3,274	13,327	4,742.0	24,739.0	85.6%
Авто замын боомтуудаар гарсан тээврийн хэрэгсэл		ш	48,386	255,153	74,394.0	303,453.0	18.9%
Авто замын боомтуудаар орсон тээврийн хэрэгсэл		ш	9,528	32,065	13,481.0	66,200.0	106.5%


¹ Зам, тээврийн салбарын 2024 оны 05 дугаар сарын статистикийн мэдээг урьдчилсан гүйцэтгэлээр “Салбарын нэгдсэн платформ”-оос нэгтгэн 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2024 оны 05 дугаар сард 11.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 55.9%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр буюу эхний 5 сард 50.2 сая тонн ачаа тээсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.3%-аар өссөн байна.

- 2024 оны 05 дугаар сард автотээврээр 7.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 79.3%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 82.8%-аар, импортоор 252.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 13.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эхний 5 сар буюу өссөн дүнгээр нийт 32.7 сая тонн ачаа тээсэн нь 35.8%-аар, экспортын ачаа 31.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 35.9%-аар, импортын ачаа 921.8 мянган тонн болж 32.4%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2024 оны 05 дугаар сард нийт 3.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 19.6%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оны 05 дугаар сараас 52.1%-аар, дамжин өнгөрсөн ачаа 488.7 мянган тонн болж 8.7%-аар тус тус өссөн бол импортын ачаа 300.2 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 9.3%-аар, экспортын ачаа 897 мянган тонн болж өмнөх оноос 3.5%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Өссөн дүнгээр нийт 17.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 14%-аар, дотоодын ачаа 9.3 сая тонн болж 29.6%-аар, импортын ачаа 1.6 сая тонн болж 17.6%-аар, дамжин өнгөрсөн ачаа 2.2 сая тонн болж 8.7%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 4.5 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 7.8%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2024 оны 05 дугаар сард 784.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 28.1%-аар өссөн. Үүнээс ачаа 766.2 тонн болж өмнөх оны 05 дугаар сараас 28.4%-аар, шуудан 18.1 тонн болж өмнөх оноос 17.4%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Өссөн дүнгээр 3730.6 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1%-аар өссөн байна. Үүнээс ачаа 3634.7 тонн тээвэрлэсэн нь 22.5%-аар, шуудан 95.9 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 81.5%-аар буурсан байна.


Зураг 1. Нийт ачаа тээвэр, мян.тонн



5 дугаар сард экспортоор 8.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 67%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын хэмжээ 36.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 28.5%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 4.5 сая тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.8%-аар буурсан бол автотээврээр 31.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 35.9%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 88%-ийг, төмөр зам 12%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2024 оны 5 дугаар сард нийт 552.7 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 0.1%-аар буурсан. Өссөн дүнгээр нийт 2.6 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 22.5%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 1.6 сая тонн ачаа импортолсон нь 17.6%-аар, автотээврээр 921.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 32.4%-аар тус тус өссөн байна. Төмөр замаар импортын ачааны 64%-ийг, автотээврээр 36%-ийг тээсэн байна. /Зураг 3/

Зураг 3. Нийт импорт





1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2024 оны 05 дугаар сард 14.2 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5%-аар өссөн бол оны эхнээс өссөн дүнгээр 63.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2024 оны 05 дугаар сард 13.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.4%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 60017 зорчигч (-11%), орон нутагт 153962 зорчигч (+34.7%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.7 сая зорчигч (+0.2%) тус тус зорчсон байна. Өссөн дүнгээр нийт 61.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 60.8 сая зорчигч (+2.8%), орон нутагт 694.5 мянган зорчигч (+23.6%), олон улсад 201 мянган зорчигч (-18.9%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2024 оны 05 дугаар сард нийт 162.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 16.8%-аар буурсан. Үүнээс олон улсад 4.2 мянган зорчигч зорчсон нь 2.2 дахин өссөн бол орон нутагт 158.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 18.2%-аар буурсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 733.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.7%-аар буурсан. Үүнээс олон улсад 14 мянган зорчигч зорчсон нь 2.1 дахин өссөн бол харин орон нутагт 719.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 14.7%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 05 дугаар сард нийт 163.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 37.3%-аар өссөн. Үүнээс олон улсад 126.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 47.9%-аар, орон нутагт 37.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 10.5%-аар тус тус өссөн байна. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 714.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 32.1%-аар өссөн бол үүнээс олон улсад 546.4 мянган зорчигч зорчсон нь 40.9%-аар, орон нутагт 167.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 9.6%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсад зорчигч

- Автотээвэр
- Төмөр зам
- Агаарын тээвэр

2024 оны эхний 5 сард олон улсад нийт 761.5 мянган зорчигч (+18.6%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 546.4 мянган зорчигч (+40.9%), автотээврээр 201 мянган зорчигч (-18.9%), төмөр замаар 14 мянган зорчигч (+112%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 72%, автотээвэр 26%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2024 оны эхний 5 сард орон нутагт нийт 1.6 сая зорчигч (+1.5%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 694.5 мянган зорчигч (+23.6%), төмөр замаар 719.7 мянган зорчигч (-14.7%), агаарын тээврээр 167.9 мянган зорчигч (+9.6%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АЧАА ТЭЭВЭР

2024 оны эхний 5 сард авто замаар нийт 32.7 сая тонн ачаа тээвэрлэснээс 31.7 сая тонн ачаа экспортолсон байна.


Хүснэгт 2

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт ачаа тээвэр	тонн	4,394,487.5	24,046,312.5	7,877,190.3	32,665,877.6	35.8%
Ачааны импорт	тонн	222,282.5	696,229.5	252,479.0	921,835.4	32.4%
Ачааны экспорт	тонн	4,172,205.0	23,350,083.0	7,624,711.3	31,744,042.2	35.9%
Ачаа эргэлт	тн.км	636,012,726.0	3,716,474,629.0	1,050,848,751.0	4,669,935,031.4	25.7%

2024 оны 05 дугаар сард автотээвэрээр 7.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 79.3%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 82.8%-аар, импортоор 252.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 13.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 05 дугаар сард 1050.8 тэрбум тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 65.2%-аар өссөн байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.


Зураг 7. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар



Эхний 5 сар буюу өссөн дүнгээр нийт 32.7 сая тонн ачаа тээсэн нь 35.8%-аар, экспортын ачаа 31.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 35.9%-аар, импортын ачаа 921.8 мянган тонн болж 32.4%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 4669.9 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 25.7%-аар өссөн байна.

2024 оны эхний 5 сарын байдлаар нийт ачаа тээврийн 31.7 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 921.8 мянган тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 53%-ийг бүрдүүлж байна. Харин импортын ачааны 80%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 5 дугаар сар

2.1.1. ЭКСПОРТЫН АЧАА, БООМТООР

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Хүснэгт 3
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт, бууралтын %
1	Нийт ачаа тээвэр	тонн	4,394,487.5	24,046,312.5	7,877,190.3	32,665,877.6	35.8%
2	Ачааны экспорт-боомтуудаар	тонн	4,172,205.0	23,350,083.0	7,624,711.3	31,744,042.2	35.9%
3	ОХУ-руу	тонн	17,727.0	71,143.0	2,329.0	16,670.1	-76.6%
4	Алтанбулаг	тонн	5,104.0	23,522.0	2,329.0	16,670.1	-29.1%
5	Боршоо	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
6	Цагаан нуур	тонн	12,623.0	47,621.0	0.0	0.0	-100.0%
7	БНХАУ-руу	тонн	4,154,478.0	23,278,940.0	7,622,382.3	31,727,372.2	36.3%
8	Бичигт	тонн	301,322.0	835,046.0	287,544.9	709,781.9	-15.0%
9	Баянхошуу	тонн	50,304.0	573,095.0	25,738.0	194,844.6	-66.0%
10	Бургастай	тонн	967.0	134,107.0	34,325.3	188,427.3	40.5%
11	Булган	тонн	265,468.0	1,239,833.0	414,760.0	1,340,091.0	8.1%
12	Гашуунсухайт	тонн	2,199,526.0	12,361,776.0	3,671,587.0	16,537,729.6	33.8%
13	Замын-Үүд	тонн	11,403.0	501,816.0	212,688.0	504,424.0	0.5%
14	Ханги	тонн	416,330.0	1,939,905.0	743,553.0	3,184,095.7	64.1%
15	Хавирга	тонн	26,307.0	58,864.0	6,278.1	15,731.1	-73.3%
16	Шивээ хүрэн	тонн	882,851.0	5,634,339.0	2,225,908.0	9,052,247.0	60.7%
17	Сүмбэр	тонн	0.0	159.0	0.0	0.0	-100.0%

2024 оны 5 дугаар сард автотээвэрээр экспортод 7.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 82.4%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын ачаа 31.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 35.9%-аар өссөн байна. Үүнд Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдсэн нь нийт экспортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2024 оны 5 сард 2.3 мянган тонн ачаа, харин өссөн дүнгээр 16.7 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оноос 76.6%-аар буурсан байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтоор 5 сард 7.6 сая тонн ачаа гарсан. Харин өссөн дүнгээр 31.7 сая тонн ачаа гарсан нь 36.3%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачаа Гашуунсухайт боомтоор 16.5 сая тонн (+33.8%) буюу нийт экспортын 52.6%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 9.1 сая тонн (+60.7%), Ханги боомтоор 3.2 сая тонн (+64.1%), Булган боомтоор 1.3 сая тонн (+8.1%), Бичигт боомтоор 709.8 мянган тонн (-15%), Замын-Үүд боомтоор 504.4 мянган тонн (+0.5%), Бургастай боомтоор 188.4 мянган тонн (+40.5%), Баянхошуу боомтоор 194.8 мянган тонн (-66%), Хавирга боомтоор 15.7 мянган тонн (-73.3%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

2.1.2 ИМПОРТЫН АЧАА, БООМТООР

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	4,394,487.5	24,046,312.5	7,549,042.0	32,337,729.4	34.5%
2	Ачааны импорт –боомтуудаар	тонн	222,282.5	696,229.5	252,479.0	921,835.4	32.4%
3	ОХУ-аас	тонн	32,629.0	125,086.0	34,885.0	166,189.9	32.9%
4	Алтанбулаг	тонн	15,591.0	64,970.0	21,049.0	81,148.9	24.9%
5	Боршоо	тонн	4,415.0	9,894.0	3,115.0	20,872.0	111.0%
6	Цагаан нуур	тонн	12,623.0	50,222.0	10,721.0	64,169.0	27.8%
7	БНХАУ-аас	тонн	189,653.5	571,143.5	217,594.0	755,645.5	32.3%
8	Бичигт	тонн	0.0	0.0	0.0	2,247.0	-
9	Баянхошуу	тонн	2,722.0	4,251.0	7.0	45.0	-98.9%
10	Бургастай	тонн	0.0	0.0	196.0	280.0	-
11	Булган	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
12	Гашуунсухайт	тонн	8,519.5	8,519.5	0.0	0.0	-100.0%
13	Замын-Үүд	тонн	178,120.0	557,343.0	212,565.0	741,901.5	33.1%
14	Ханги	тонн	167.0	456.0	0.0	0.0	-100.0%
15	Хавирга	тонн	125.0	574.0	4,826.0	11,172.0	1846.3%
16	Шивээ хүрэн	тонн	0.0	0.0	0.0	0.0	-

Автотээврээр 2024 оны 05 дугаар сард импортоор 252.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 13.6%-аар өссөн байна. Үүнээс 32.9 мянган тонныг ОХУ-аас, 217.6 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.


2024 оны эхнээс өссөн дүнгээр импортын ачаа 921.8 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 32.4%-аар өссөн байна. Үүнд Боршоо, Хавирга боомтоор орж ирсэн ачааны хэмжээ нэмэгдсэн нь нийт импортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

Эхний 5 сард ОХУ-аас 166.2 мянган тонн, БНХАУ-аас 755.6 мянган тонн ачаа оруулж ирсэн байна. Импортын ачааны 82%-ийг БНХАУ-аас, 18%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 80.5%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.**

БНХАУ-аас Замын-Үүд боомтоор 741.9 мянган тонн ачаа (+32.3%), Бичигт боомтоор 2.2 мянган тонн ачаа, Хавирга боомтоор 11.2 мянган тонн ачаа оруулсан байна.

ОХУ-аас Алтанбулаг боомтоор 81.1 мянган тонн (+24.9%), Цагааннуур боомтоор 64.2 мянган тонн (+27.8%), Боршоо боомтоор 20.9 мянган тонн (+111%) ачаа тус тус орж иржээ. /Зураг 10/

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор



Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 5 дугаар сар

2.1.3. АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нүүрс	тонн	4,031,522.7	21,855,584.3	6,997,026.3	30,364,905.5	38.9%
Газрын тос	тонн	50,304.3	244,375.5	24,737.8	193,844.4	-20.7%
Зэсийн баяжмал	тонн	63,360.0	284,720.0	89,430.0	386,007.0	35.6%
Төмрийн хүдэр	тонн	966.6	134,265.3	59,352.2	245,270.7	82.7%
Жонш	тонн	0.0	0.0	9,386.2	38,174.2	-
Бусад	тонн	26,051.4	856,432.4	444,778.8	529,169.5	-38.2%

Авто замын боомтоор гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 05 дугаар сард 7 сая тонн (+73.6%), зэсийн баяжмал 89.4 мянган тонн (+41.1%), газрын тос 24.7 мянган тонн (-50.8%), төмрийн хүдэр 59.4 мянган тонн (*60), жонш 9.4 мянган тонн, бусад ачаа 444.8 мянган тонн ачаа гаргасан байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нүүрс 30.4 сая тонн (+38.9%), зэсийн баяжмал 386 мянган тонн (+35.6%), төмрийн хүдэр 245.3 мянган тонн (+82.7%), газрын тос 193.8 мянган тонн (-20.7%), жонш 38.2 мянган тонн, бусад 529.2 мянган тонн ачаа тус тус экспортолсон байна. /Зураг 11/

Зураг 11 .Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



2.1.4. АЧАА ЭРГЭЛТ, БООМТООР

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа эргэлт	тн.км	636,012,726.0	3,716,474,629.0	1,050,848,751.0	4,669,935,031.4	25.7%
2	Алтанбулаг	тн.км	475,985.0	2,035,316.0	537,694.0	2,249,835.9	10.5%
3	Бичигт	тн.км	24,105,760.0	66,803,680.0	23,003,592.0	56,962,312.0	-14.7%
4	Баянхошуу	тн.км	33,936,640.0	369,501,440.0	16,476,800.0	124,729,344.0	-66.2%
5	Бургастай	тн.км	77,360.0	10,728,560.0	2,761,704.0	15,096,584.0	40.7%
6	Гашуунсүхайт	тн.км	507,850,465.0	2,845,167,965.0	844,465,010.0	3,803,677,808.0	33.7%
7	Замын-Үүд	тн.км	1,326,661.0	7,414,113.0	2,976,771.0	8,724,278.5	17.7%
8	Цагаан нуур	тн.км	2,524,600.0	9,784,300.0	1,072,100.0	6,416,900.0	-34.4%
9	Ханги	тн.км	8,329,940.0	38,807,220.0	14,871,060.0	63,681,914.0	64.1%
10	Шивээ хүрэн	тн.км	57,385,315.0	366,232,035.0	144,684,020.0	588,396,055.0	60.7%

2024 оны эхнээс өссөн дүнгээр автотээврийн ачаа эргэлт нийт 4669.9 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 25.7%-аар өссөн байна. Үүнээс ачаа эргэлт хамгийн их байгаа боомт болох Гашуунсүхайтаар 3803.7 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 82%-ийг дангаар бүрдүүлж байна. Харин хамгийн их өсөлттэй байгаа боомт нь Ханги буюу тус боомтоор 63.7 сая тонн км ачаа эргэлт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 64.1%-аар өссөн байна. /Хүснэгт 6/

2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Автотээвэрээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр 61.7 сая зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 2.9%-аар өссөн байна.

Хүснэгт 7

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	<i>хун</i>	13,818,282.0	59,906,572.0	13,876,375.0	61,673,316.0	2.9%
Олон улсад зорчигчид	<i>хун</i>	67,414.0	247,799.0	60,017.0	201,045.0	-18.9%
Хот хоорондын зорчигч	<i>хун</i>	114,267.0	561,935.0	153,962.0	694,538.0	23.6%
Хот доторх нийтийн тээвэрээр зорчигч	<i>хун</i>	13,636,601.0	59,096,838.0	13,662,396.0	60,777,733.0	2.8%
Зорчигч эргэлт		182.7	837.4	201.6	850.8	1.6%



Автотээвэрээр 2024 оны 05 дугаар сард 13.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.4%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 60017 зорчигч (-11%), орон нутагт 153962 зорчигч (+34.7%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.7 сая зорчигч (+0.2%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 61.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээвэрээр 60.8 сая зорчигч (+2.8%), орон нутагт 694.5 мянган зорчигч (+23.6%), олон улсад 201 мянган зорчигч (-18.9%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.6%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.1%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 12/

2.3. АВТО ЗАМЫН БООМТООР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

Хүснэгт 8

Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Орсон тээврийн хэрэгсэл	57,914	287,218	87,875	369,653.0	28.7%
БНХАУ-аас	7,620	24,484	10,474	55,545.0	126.9%
Бичигт	0	0	0.0	0.0	-
Баянхошуу	85	258	17.0	20.0	-92.2%
Булган	172	447	0.0	0.0	-100.0%
Бургастай	0	2	6.0	9.0	350.0%
Гашуунсухайт	177	1,142	1,054.0	2,240.0	96.1%
Шивээхүрэн	76	151	269.0	21,547.0	14169.5%
Замын-Үүд	7,044	22,383	8,984.0	31,171.0	39.3%
Ханги	1	17	61.0	218.0	1182.4%
Хавирга	65	84	83.0	340.0	304.8%
ОХУ-аас	1,908	7,581	3,007	10,655.0	40.5%
Алтанбулаг	1,063	4,431	1,275.0	5,041.0	13.8%
Боршоо	181	446	126.0	900.0	101.8%
Цагааннуур	664	2,704	1,606.0	4,714.0	74.3%
Гарсан тээврийн хэрэгсэл	48,386	255,153	74,394	303,453.0	18.9%
БНХАУ-руу	34,609	190,698	71,069	291,481.0	52.8%
Бичигт	0	0	0.0	5,755.0	-
Баянхошуу	1,360	6,698	1,145.0	5,960.0	-11.0%
Булган	3,571	14,578	5,670.0	18,480.0	26.8%
Бургастай	48	2,385	1,060.0	5,984.0	150.9%
Гашуунсухайт	15,793	92,439	29,835.0	132,922.0	43.8%
Шивээхүрэн	7,641	45,023	16,706.0	2,281,925.0	4968.4%
Замын-Үүд	342	2,418	8,917.0	13,483.0	457.6%
Ханги	5,531	26,503	7,736.0	35,956.0	35.7%
Хавирга	323	651	0.0	218.0	-66.5%
Сүмбэр	0	3	0.0	0.0	-100.0%
ОХУ-руу	13,777	64,455	3,325	11,972.0	-81.4%
Алтанбулаг	12,547	60,365	1,061.0	4,297.0	-92.9%
Боршоо	162	404	150.0	892.0	120.8%

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 5 дугаар сар

Цагааннуур	1,068	3,686	2,114.0	6,783.0	84.0%
------------	-------	-------	---------	---------	-------

Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Монгол Улсын авто замын боомтоор 2024 оны 05 дугаар сард нийт 87875 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс 13481 тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны мөн үеэс 41.5%-аар, 74394 тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны мөн үеэс 53.8%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 8/

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 369653 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 28.7%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаа тээврийн хэрэгсэл 66200 буюу 2 дахин, гарсан тээврийн хэрэгсэл 303453 болж өмнөх оны мөн үеэс 18.9%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 13/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР
3.1. АЧАА ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2024 оны эхний 5 сард нийт 17.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх онтой харьцуулахад 14%-аар өслөө.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Ачаа тээвэрлэлт	<i>мян.тн</i>	2,822.8	15,361.7	3,377.4	17,518.8	14.0%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	2,634.2	13,380.4	2,550.4	13,507.9	1.0%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	188.6	606.4	214.6	938.4	54.8%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>		275.9	344.8	1,281.2	364.4%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>		1,099.0	267.6	1,575.7	43.4%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>		0.0	130.0	345.5	-
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	1,112.2	7,136.7	1,691.4	9,250.9	29.6%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	923.6	5,155.4	864.4	5,240.1	1.6%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	188.6	606.4	214.6	938.4	54.8%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>		275.9	344.8	1,281.2	364.4%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>		1,099.0	267.6	1,330.6	21.1%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>		0.0	130.0	590.6	-
Импорт ачаа	<i>мян.тн</i>	330.9	1,395.1	300.2	1,641.0	17.6%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	930.0	4,831.8	897.0	4,455.7	-7.8%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	449.7	1,998.1	488.7	2,171.0	8.7%

Хүснэгт 9


Төмөр замын тээврээр 2024 оны 05 дугаар сард нийт 3.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 19.6%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оны 05 дугаар сараас 52.1%-аар, дамжин өнгөрсөн ачаа 488.7 мянган тонн болж 8.7%-аар тус тус өссөн бол импортын ачаа 300.2 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 9.3%-аар, экспортын ачаа 897 мянган тонн болж өмнөх оноос 3.5%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 9/

Өссөн дүнгээр нийт 17.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 14%-аар, дотоодын ачаа 9.3 сая тонн болж 29.6%-аар, импортын ачаа 1.6 сая тонн болж 17.6%-аар, дамжин өнгөрсөн ачаа 2.2 сая тонн болж 8.7%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 4.5 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 7.8%-аар буурсан байна. /Зураг 14/

Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн




Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь




Эхний 5 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 13.5 сая тонн буюу 77.1%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.6 сая тонн буюу 9%-ийн ачааг “Монголиантранс Ложистик” ХХК, 1.3 сая тонн буюу 7.3%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 938.4 мянган тонн буюу 5.4%-ийн ачааг “Монголын төмөр зам” ТӨХК, 345.5 мянган тонн ачаа буюу нийт ачааны 2%-ийг “Монголиантранс Лайн” ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 15/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 9.3 сая тонн буюу 52.8%-ийг дотоодын ачаа, 4.5 сая тонн буюу 25.4%-ийг экспортын ачаа, 2.2 сая тонн буюу 12.4%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1.6 сая тонн буюу 9.4%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 16/

Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл



Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Дотоодод тээвэрлэсэн 9.3 сая тонн ачааны 5.2 сая тонн ачаа буюу 56%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.3 сая тонн ачаа буюу 14%-ийг “Монголиантранс Ложистик” ХХК, 1.3 мянган тонн буюу 14%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 938.4 мянган тонн ачаа буюу 10%-ийг “Монголын төмөр зам” ТӨХК, 590.6 мянган тонн буюу 6%-ийг “Монголиантранс Лайн” ХХК тус тус эзэлж байна. /Зураг 17/

Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 05 дугаар сарын хоногийн мэдээ, 2024.05.01-2024.05.31




Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 5 дугаар сар

“УБТЗ” ХНН-ийн ачаа тээврийн 05 дугаар сарын хоногийн мэдээг Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. /Зураг 18/

2024 оны эхний улирал буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.05.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг19/

Зураг 19 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



Байгууллагуудын хоногт тээвэрлэх хүчин чадал буюу ачаа тээврийн хоногийн дундажийг эхний 5 сарын байдлаар тооцоход “УБТЗ” ХНН хоногт дунджаар 86.9 мянган тонн, “МТЛожистик” ХХК нь 10.4 мянган тонн, “ТТЗ” ХХК нь 8.4 мянган тонн, “МТЗ” ТӨХК нь 6.2 мянган тонн, “МТЛайн” ХХК нь хоногт дунджаар 2.3 мянган тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна.


3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Төмөр замаар 2024 оны эхний 5 сард 14 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 2.1 дахин өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Зорчигч тээвэрлэлт	<i>мян.хүн</i>	195.9	850.0	162.9	733.7	-13.7%
Олон улс	<i>мян.хүн</i>	1.9	6.6	4.2	14.0	112.0%
Орон нутаг	<i>мян.хүн</i>	194.0	843.4	158.7	719.7	-14.7%
Зорчигч эргэлт	<i>сая хүн.км</i>	74.4	302.5	65.2	303.8	0.4%

2024 оны 05 дугаар сард нийт 162.9 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 16.8%-аар буурсан. Үүнээс олон улсад 4.2 мянган зорчигч зорчсон нь 2.2 дахин өссөн бол орон нутагт 158.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 18.2%-аар буурсан байна.

Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр




Оны эхнээс өссөн дүнгээр нийт 733.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.7%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 14 мянган зорчигч зорчсон нь 2.1 дахин өссөн бол харин орон нутагт 719.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 14.7%-аар буурсан байна.

Орон нутгийн зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих, зорчигч вагоны тариф нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт төмөр замаар зорчигчдын 98% нь орон нутагт зорчсон бол 2% нь олон улсад зорчсон байна. /Зураг 20/

Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор




2024 оны эхний 4 сар буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.05.31-ний өдөр хүртэл “УБТЗ” ХНН нь нийт 733.7 мянган зорчигч төмөр замаар тээвэрлэсэн байна. Эхний 5 сарын байдлаарх хоногийн дунжийг тооцоход төмөр замаар хоногт дунджаар 4772 зорчигч төмөр замаар зорчоод байна. /Зураг 21/

БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР
4.1 АЧАА ТЭЭВЭР

Хүснэгт 11

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	612.2	3,484.8	784.3	3,730.6	7.1%
2	олон улсад	тн	610.3	3,476.7	782.5	3,721.7	7.0%
3	орон нутагт	тн	1.9	8.1	1.8	8.9	9.4%
4	Нийт ачаа	тн	596.8	2,966.8	766.2	3,634.7	22.5%
5	олон улсад	тн	595.3	2,960.7	764.5	3,625.9	22.5%
6	орон нутагт	тн	1.5	6.1	1.7	8.8	44.8%
7	Нийт шуудан	тн	15.4	518.1	18.1	95.9	-81.5%
8	олон улсад	тн	15.0	516.0	18.0	95.8	-81.4%
9	орон нутагт	тн	0.4	2.0	0.1	0.1	-96.6%




Агаарын тээвэрээр 2024 оны 05 дугаар сард 784.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 28.1%-аар өссөн. Үүнээс ачаа 766.2 тонн болж өмнөх оны 05 дугаар сараас 28.4%-аар, шуудан 18.1 тонн болж өмнөх оноос 17.4%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр 3730.6 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1%-аар өссөн байна. Үүнээс ачаа 3634.7 тонн тээвэрлэсэн нь 22.5%-аар, шуудан 95.9 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 81.5%-аар буурсан байна. /Зураг 22/


Оны эхнээс өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 3721.7 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 7%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 8.9 тонн болж өмнөх оны мөн үеэс 9.4%-аар өссөн байна. /Зураг 23/

Агаарын тээвэрээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.8%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.2%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.4%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.6%-ийг шуудан эзэлж байна.

Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт 714.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 32.1%-аар өслөө.

Хүснэгт 12

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	<i>хүн</i>	119,303	540,939	163,843	714,312	32.1%
Олон улсад	<i>хүн</i>	85,576	387,806	126,573	546,443	40.9%
Орон нутагт	<i>хүн</i>	33,727	153,133	37,270	167,889	9.6%

Зураг 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо




2024 оны 05 дугаар сард агаарын тээврээр нийт 163.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 37.3%-аар өссөн. Үүнээс олон улсад 126.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 47.9%-аар, орон нутагт 37.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 10.5%-аар тус тус өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 714.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 32.1%-аар өссөн бол үүнээс олон улсад 546.4 мянган зорчигч зорчсон нь 40.9%-аар, орон нутагт 167.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 9.6%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 12/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь харагдаж байна./Зураг 26/

Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 13


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралт %
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт зорчигч тээвэр	<i>хүн</i>	119,303	540,939	163,843	714,312	32.1%
2	Олон улсад	<i>хүн</i>	85,576	387,806	126,573	546,443	40.9%
3	чиглэл Сөүл	<i>хүн</i>	37,195	169,544	44,855	178,575	5.3%
4	Бээжин	<i>хүн</i>	9,886	26,622	20,397	91,407	243.4%
5	Истанбул	<i>хүн</i>	10,694	47,946	12,822	53,038	10.6%
6	Токио	<i>хүн</i>	8,382	33,898	9,762	43,446	28.2%
7	Бусан	<i>хүн</i>	4,826	14,317	8,206	17,084	19.3%
8	ХонКонг	<i>хүн</i>	4,830	15,254	6,027	31,342	105.5%
9	Франкфурт	<i>хүн</i>	2,342	13,854	4,628	23,078	66.6%
10	Хөх хот	<i>хүн</i>	715	3,313	4,435	16,667	403.1%
11	Хайлаар/Хөлөнбуйр	<i>хүн</i>	92	92	3,231	9,693	10435.9%
12	Гуанжоу	<i>хүн</i>	648	2,471	2,255	5,053	104.5%
13	Алмата	<i>хүн</i>	1,872	6,297	1,906	7,137	13.3%
14	Эрхүү	<i>хүн</i>	945	3,533	1,383	5,958	68.6%
15	Манжуур	<i>хүн</i>	853	1,692	1,314	4,978	194.2%
16	Чанша/Фукуок	<i>хүн</i>	0	279	483	1,130	305.0%
17	Муан	<i>хүн</i>		0	1,857	1,857	-
18	Хайкоу/Хайнань	<i>хүн</i>		0	701	4,485	-

2024 оны эхнээс өссөн дүнгээр олон улсад нийт 546.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн 40.9%-аар өссөн. Сөүл чиглэлд мянган зорчигч 178.6 (+5.3%), Бээжин хот руу 91.4 мянган зорчигч (+243.4%), Истанбул хот руу 53 мянган зорчигч (+10.6%), Токио чиглэлд 43.4 мянган зорчигч (+28.2%), Бусанруу 17.1 мянган зорчигч (+19.3%), ХонгКонг-руу 31.3 мянган зорчигч (+105.5%), Франкфурт чиглэлд 23.1 мянган зорчигч (+66.1%), Хөх хотруу 16.7 мянган зорчигч (+403.1%), Хайлаар/ Хөлөнбуйр чиглэлд 9.7 (*100), Гуанжоу чиглэлд 5.1 (+104.5%), Алмата хотруу 7.1 (+13.3%), Эрхүү хотруу 5.9 (+68.6%), Манжуур хотруу 4.9 (+194.2%), Муан чиглэлд 1857 зорчигч тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 27/

Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр эхний 5 сард олон улсад 269836 мянган зорчигч зорчсон бол “Korean Air”-ийн нислэгээр 51.4 мянга, “Airchina”-ийн нислэгээр 51.2 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 43.5 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 32 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 31.9 мянга, “Изинис Эйрвейз” ХХК-ийн нислэгээр 12 мянга, Жэжү айр нислэгээр 24.4 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 16.9 мянга, Ираеро нислэгээр 6.5 мянган зорчигч, Айр Бусан нислэгээр 3152, Красавиа нислэгээр 688, захиалгат нислэгээр 2864 зорчигч зорчсон байна. /Зураг 28/

4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 14

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт зорчигч тээвэр	хүн	119,303	540,939	163,843	714,312	32.1%
2	Орон нутагт зорчигч тээвэр	хүн	33,727	153,133	37,270	167,889	9.6%
3	чиглэл Ховд	хүн	778	3,377	1,558	5,391	59.6%
4	Улаангом	хүн	143	784	514	1,438	83.4%
5	Алтай	хүн	0	36	863	3,378	9283.3%
6	Оюутолгой	хүн	31,725	144,406	31,335	146,551	1.5%
7	Оюутолгой/Даланзадгад	хүн		0	47	457	-
8	Мөрөн	хүн		99	353	1,454	1368.7%
9	Өлгий	хүн	563	2,210	974	3,690	67.0%
10	Улиастай	хүн	303	1,585	548	2,269	43.2%
11	Даланзадгад	хүн	20	20	758	1,783	8815.0%
12	Мөрөн/Улаангом	хүн		0	175	1,084	-
13	Бусад			0	46	280	-


Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2024 оны 05 дугаар сард орон нутагт нийт 37.3 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 10.5%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 167.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.6%-аар өссөн бол Оюутолгой чиглэлд нийт 146.6 мянган зорчигч тээвэрлэсэн нь 1.5%-аар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн бүх чиглэл тэр дундаа Алтай, Мөрөн, Даланзадгад чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2024 оны эхний 5 сард агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 63% буюу 106 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 21% буюу 35.3 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 16% буюу 26.6 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 9.6%-аар өссөн бол “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 4.2%-аар, “Аэро Монголиа” ХХК зорчигч 16.4%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 30/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

Хүснэгт 15

Үзүүлэлт	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт нислэгийн тоо	4,659	19,444	6,505	32,208	65.6%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	3,274	13,327	4,742	24,739	85.6%
Хөөрөлт, буулт	1,385	6,117	1,763	7,469	22.1%
Олон улсын хөөрөлт, буулт	664	3,008	931	4,213	40.1%
Орон нутгийн хөөрөлт, буулт	721	3,109	832	3,256	4.7%

2024 оны 05 дугаар сард нийт нислэгийн тоо 6505 болж өмнөх оны мөн үеэс 39.6%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 4742 болж өмнөх оны мөн үеэс 44.8%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 931 болж 40.2%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 832 болж 15.4%-аар тус тус байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нислэгийн тоо 32208 болж өмнөх оны мөн үеэс 65.6%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 24739 болж өмнөх оны мөн үеэс 85.6%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 4213 болж 40.1%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 3256 болж өмнөх оны мөн үеэс 4.7%-аар тус тус үзүүлэлттэй байна. /Зураг 31/

Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

